



IV-VI/2021



Барилгын өртөг өмнөх улирлаас 30.2 хувиар өссөн байна.


Барилгын өртгийн ерөнхий индекс (2015=100) 2021 оны 2 дугаар улиралд 173.7 болж, барилгын өртөг өмнөх улирлаас 30.2 хувь, өмнөх оны мөн үеэс 35.7 хувиар өслөө.

Харин орон сууцны барилгын өртгийн индекс (2015=100) 2021 оны 2 дугаар улиралд 195.8 болж, барилгын өртөг нь өмнөх улирлаас 28.9 хувь, өмнөх оны мөн үеэс 40.3 хувиар өссөн байна. Орон сууцны барилгын өртөг өмнөх улирлаас 28.9 хувиар өсөхөд материалын өртөг 32.6 хувь, цалингын зардал 30.2 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Орон сууцны бус барилгын өртгийн индекс (2015=100) 170.1 болж, өртөг нь өмнөх оны мөн үеэс 35.4 хувь, өмнөх улирлаас 31.2 хувиар өссөн байна. Орон сууцны бус барилгын өртөг өмнөх улирлаас 31.2 хувиар өсөхөд сургуулийн барилгын өртөг 35.2 хувь, эмнэлэг, сувиллын барилгын өртөг 32.5 хувь, конторын барилгын өртөг 26.5 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

Инженерийн барилга, байгууламжийн өртгийн индекс (2015=100) 142.1 болж, өртөг нь өмнөх оны мөн үеэс 20.2 хувь, өмнөх улирлаас 20.1 хувиар өссөн байна. Инженерийн барилга, байгууламжийн өртөг өмнөх улирлаас 20.1 хувиар өсөхөд авто замын байгууламжын өртөг 20.3 хувь, эрчим хүчний байгууламжын өртөг 19.0 хувиар өссөн нь нөлөөлжээ.

Зураг 1. Барилгын өртгийн индекс (2015=100), улирлаар, хувь



Хүснэгт 1. Барилгын өртгийн индекс, дэд салбараар, хувиар

Дэд салбар	2021 IV-VI	2021 IV-VI	2021 IV-VI
	2015	2020 IV-VI	2021 I-III
	2015=100		
Ерөнхий индекс	173.7	135.7	130.2
Орон сууцны барилга	195.8	140.3	128.9
Орон сууцны бус барилга	170.1	135.4	131.2
Инженерийн барилга, байгууламж	142.1	120.2	120.1

Ойлголт, тодорхойлолт:

Барилгын өртгийн индекс: Барилга, байгууламжийг барьж байгуулахад зарцуулж буй барилгын материал, машин, механизм, цалингийн үнийн өөрчлөлтийг илэрхийлнэ.

Барилгын төрөл: Барилгын төрлийг орон сууцны барилга, орон сууцны бус барилга, инженерийн барилга, байгууламж гэж хуваана.

Тооцох аргачлал:

Барилгын материал, цалин, машин, механизмын жинг тооцон, сонгогдсон барилгын материалын үнэ, машин, механизмын тариф, цалинг цуглуулж, тус бүрийн индексийг тооцно. Индексийг тооцохдоо Ласпейресийн үнийн индексийн томъёог ашиглана.

$$I_1 = \frac{\sum P_1 Q_0}{\sum P_0 Q_0}$$

P0 - суурь үеийн үнэ,

P1 - тайлант үеийн үнэ,

Q0 - суурь үеийн тоо, хэмжээ



Эх үүсвэр: ҮСХ, Барилгын өртгийн мэдээ

Ангилал, код: ЭЗҮАСА, БУНА

Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 11 дүгээр сарын 17

Эдийн засгийн статистикийн газрын
дарга Э.Эрдэнэсан
Утас : (976-51)-266414

Эдийн засгийн статистикийн газрын
статистикч Т.Жигжидсүрэн
Утас : (976-51)-261561



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212